



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/490

Мөрөн сум

Газар эзэмших эрхийг дуусгавар болгож,  
өмчлүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дүгээр зүйлийн 60.1.1, 66 дүгээр зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 7 дугаар зүйлийн 7.1, 12 дугаар зүйлийн 12.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны X хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын өргөн мэдүүлснээр нэр бүхий иргэний гаргасан өргөдлийг үндэслэн энэхүү захирамжийн нэгдүгээр хавсралтад заасан 1 иргэний 588м<sup>2</sup> газар эзэмших эрхийг 2023 оны 09 дугаар сарын 25-ны өдрөөр тасалбар болгон дуусгавар болгож, мөн өдрөөс эхлэн тус иргэдэд нийт 588м<sup>2</sup> газрыг энэ захирамжийн хоёрдугаар хавсралтад заасны дагуу гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлсүгэй.

2. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газраа өмчилж авахаар шийдвэр гаргуулсан иргэдийн газрыг улсын бүртгэлд бүртгэж, баталгаажуулахыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул)-т даалгасугай.

3. Хувийн хэргийн бүрдүүлэлтийг ханган, өмчилсөн газрыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, мэдээллийн санд оруулж, захиргааны актыг оролцогчдод мэдэгдэхийг аймгийн Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4. Энэхүү шийдвэрийг эрх хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдүүд эс зөвгөөрвөл мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5. Газар өмчлөгчийн үүргийн биелэлтэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Мөрөн сумын Засаг дарга (Д.Идэрмөнх)-д даалгасугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсхөд)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023

6712011078



Аймгийн Засаг даргын 2023 оны 09 дугаар сарын 25-ны  
өдрийн А/49 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

ГЭР БҮЛИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ЗОРИУЛАЛТААР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ЗАХИРАМЖИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ЖАГСААЛТ

№	Ургийн овог	Эцэг эхийн нэр	Өөрийн нэр	Регистрийн дугаар	Зориулалт	Газрын байршил /хаяг/	Газрын хэмжээ /м2/	Нэгж талбарын дугаар	Эзэмших эрхийн	
									Огноо дугаар	Хавсралтын дугаар
1	Ой мод	Нямхүү	Улаанхүү	РГ90022319	Гэр, орон сууцны хашааны газар	18.35а.5	588	6712015107	2023.09.13 A/223	3 дугаар заалт

588

— оОо —



Аймгийн Засаг даргын 2023 оны 09 дугаар сарын 25-ны  
өдрийн А/139 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

ГЭР БҮЛИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ЗОРИУЛАЛТААР ГАЗАР ӨМЧЛӨГЧ ИРГЭДИЙН ЖАГСААЛТ

№	Ургийн овог	Эцэг эхийн нэр	Өөрийн нэр	Регистрийн дугаар	Зориулалт	Газрын байршил /хаяг/	Газрын хэмжээ	Газрын үнэ	Нэгж талбарын дугаар
1	Ой мод	Нямхүү	Улаанхүү	РГ90022319	Гэр, орон сууцны хашааны газар	13.35а.5	588	1764.0	6712015107

588

— 000 —